

**2024 ОНЫ
ОНЦЛОХ**

NES
System



International Organization for Standardization
ISO
31000:2018
Risk Management



ТЭРБУМ.МОН
ТӨРӨМӨН ХӨГЖЛИЙН БОДЛОГО





506.1
Тэрбум ₮



International Organization for Standardization
ISO
37301:2021
Compliance
Management System

5,822
ӨРХ



**АКТИВ
ГУЧИН ТАВ**
ТУСАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИ



**АКТИВ
ГУЧИН ЗУРГАА**
ТУСАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИ




8.5
тэрбум ₮

Дотоодын биржийн
бус зах зээл



\$ 225,000,000
HULAN BOND

**ЦАХИМ
ШИЛЖИЛТ**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТАНИЛЦУУЛГА**

АЛСЫН ХАРАА

Монгол өрхийн тав тухтай амьдралыг дэмжих орон сууцны санхүүжилтийн экосистемийг бий болгоно.

ЭРХЭМ ЗОРИЛГО


Орон сууцны санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах замаар ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлдэг.

ҮНЭТ ЗҮЙЛС

Ёс зүй: Бид бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйг дээдлэн, хариуцлагатай үйл ажиллагааг эрхэмлэн ажиллаж, оролцогч талуудад итгэлтэй байдлыг хадгална.

Тогтвортой хөгжил: Бид байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг ханган ажиллана.

Мэргэшсэн байдал: Бид ажилчдын эрдэм мэдлэг, туршлагыг эрхэмлэн хөгжинө.



АГУУЛГА

ТУЗ-ийн даргын мэндчилгээ	4
Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол	5-6
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	7
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	8
2024 оны үйл ажиллагааны тайлан	9-14
Компанийн засаглал	9
Компанийн бүтэц	10
Компанийн 2024 оны онцлох үйл явдлууд	11
Компанийн бизнесийн үйл ажиллагаа	12-14
Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол	15
Хараат бус аудиторын тайлан	16-18
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	19-21
Төлөөлөн удирдах зөвлөлийн үрэлдэхүүн	19
Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа	20-21
Төлөөлөн удирдах зөвлөлийн бусад үйл ажиллагаа	21
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны дүгнэлт	22
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүд	23-24
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсууд	25-28
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бүртгүүлэх болон оролцож, санал өгөх заавар	29

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн түмэн амар амгаланг айлтган мэндчилж байна.

Бид 2024 онд дотоод, гадаадын зах зээлд идэвхтэй ажиллаж, олон улсын хөрөнгийн зах зээлд идэвхтэй ажиллаж, хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэн ажиллаа. Үүний нэг тод жишээ бол бид Америкийн Нэгдсэн Улсын Хөгжлийн Санхүүжилтийн Байгууллагаас (DFC) 150 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг авахаар боллоо. Энэхүү санхүүжилт нь Монголын орон сууцны ипотекийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах, эмэгтэйчүүд болон бага, дунд орлоготой өрхүүдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой болох юм.

DFC-ийн энэ удаагийн санхүүжилт нь Монгол Улсын банк, санхүүгийн байгууллагад олгож байгаа хамгийн өндөр дүнтэй, урт хугацаатай санхүүжилт болж байгаа бөгөөд орон сууцны санхүүжилтийн зориулалттай болон анх удаа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасжуулалтын зарчмаар олгогдох ипотекийн зээлийн эх үүсвэр гэдгээр онцлог.

МИК 2024 онд “Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 506 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргасан. Мөн олон улсын зах зээл болон дотоодын зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр тайлант хугацаанд банк санхүүгийн байгууллагуудаас 20 удаагийн хэлцлээр 164.07 тэрбум төгрөгийн багцыг буцаах нөхцөлтэйгөөр худалдан авч, тус санхүүгийн салбарын хөрвөх чадварыг сайжруулсан байна.

Тухтай амьдралын эхлэлийг хамтдаа бүтээж буй Та бүхэнд талархал илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн,

Ч.ХАШЧУЛУУН,
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

"МИК ХОЛДИНГ" ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№25/06

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 2 хэсэг, 65 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 1, 3, 4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор батлагдаж, 2021 оны 45 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 2, 9 дүгээр зүйлийн 7.11, 7.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 16/22 дугаартай тогтоолоор батлагдаж, 2021 оны 21/08 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам”-ыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт цахимаар хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
 2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.
 3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг Хавсралт 1-р баталж, 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр болон мөн оны 4 дүгээр сарын 07-ны өдөр тус тус хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2025 оны 3

дугаар сарын 26-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж, танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-г томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Н.Болор-Эрдэнэ, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Хянан нийцүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн;

Гишүүн: Б.Тулга, “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн Программист.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг хурлын дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3-р, санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр “Санал авах хуудас”-ны загварыг Хавсралт 4, 5-р тус тус баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудаар дамжуулан хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд, хурлаар шийдвэрлэх асуудалд өгсөн саналыг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг хүртэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот хаягт байрлах компанийн байранд хүлээн авах болон түүнтэй бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Тооллогын комисст тус тус үүрэг болгосугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.

14. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,

Ч.ХАШЧУЛУУН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр:

“МИК Холдинг” ХК

Хаяг:

Монгол Улс, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, Д.Сүхбаатарын талбай гудамж,
11 тоот. Утас: 328267

Хурал хуралдах огноо, цаг, газар:

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагаас цахим /live.mik.mn/-аар хуралдах

Бүртгэлийн өдөр:

2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Хувьцаа эзэмшигчид өөрийн бүртгэлтэй үнэт цаасны компани болон компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд хандан биечлэн, эсвэл цахимаар хурлын баримт бичигтэй танилцаж болно.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба нь 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүртэл Даваа-Баасан гарагт 09:00-17:00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүний мэдээлэл:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Г.Саруул, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Цахим шуудан: saruul@mik.mn
Утас: 95908267

ТУЗ-ийн ажлын албаны хуульч: Х.Маралмаа, ТУЗ-ийн ажлын албаны хуульч
Цахим шуудан: maralmaa@mik.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцагч
1.	Хурлын ирцийг бүртгэх	11:00-11:15	Тооллогын комисс
2.	Хурлын ирцийг мэдээлэх	11:15-11:25	Тооллогын комисс
3.	Хурлыг нээх	11:25-11:30	Хурлын дарга
	Хэлэлцэх асуудлуудын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина.		
4.	1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;	11:30-12:10	Гүйцэтгэх захирал, Санхүүгийн хөндлөнгийн аудитын байгууллагын төлөөлөл
	2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;		Гүйцэтгэх захирал
	3. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай;		ТУЗ-ийн дарга
	4. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай.		ТУЗ-ийн дарга
5.	Хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт	12:10-12:20	[•]
6.	Хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуултад хариулах	12:20-12:30	[•]
7.	Хурлаас гарах шийдвэрийн төслийг уншиж танилцуулах	12:30-12:35	Хурлын дарга
8.	Санал хураалт явуулах	12:35-12:45	Тооллогын комисс
	Санал хураалтын үр дүнг нэгтгэж, мэдээлэх	12:45-13:00	Тооллогын комисс
9.	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	13:00-13:05	Хурлын дарга
10.	Хурлыг хаах	13:05-13:10	Хурлын дарга
11.			

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“МИК Холдинг” ХК-ийн нийт хувьцааны 17.23 хувийг төрийн өмчит байгууллагууд, 82.68 хувийг банк болон хувийн хэвшлийн байгууллагууд, 0.09 хувийг хувь хүмүүс эзэмшиж байгаа бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 233 хувьцаа эзэмшигчтэй байна.

“МИК Холдинг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Төрийн өмчит
байгууллагын эзэмшил

17.23%



МУХБ, Төрийн банк

Хувийн хэвшлийн
байгууллагууд

82.68%



6 банк болон бусад аж
ахуйн нэгж

Хувь хүн

0.09%



204 хувь хүн

Эх сурвалж: “ҮЦТХТ” ХХК /2024.12.31/

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны тоо ширхэг	Хувь хэмжээ
1. Монгол Улсын хөгжлийн банк	3,081,955	14.88%
2. "Си Эн Би Консалтинг" ХХК	2,608,480	12.60%
3. "Азиа Дайверсифайд Рийл Истэйт Фанд Нэг Хувийн ХОС" ХХК	2,312,500	11.17%
4. Худалдаа хөгжлийн банк	2,070,932	10.00%
5. “Ти Ди Би Капитал” ХХК	1,232,785	5.95%
6. “Ти Ди Би Секьюритиз” ХХК	1,097,953	5.30%

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 24/07 дугаартай тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг баримтлан 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 11:00 цагаас "live.mik.mn"-р дамжуулан цахимаар зохион байгуулж, хуралдууллаа.

Тус хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, хараат бус гишүүн Чулуундоржийн Хашчулуун удирдан явуулж, хуралд тооллогын комисс, хурал зохион байгуулах комисс болон компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан “Эрнст энд Янг Монголиа аудит” ХХК-ийн төлөөлөл оролцсон бөгөөд компанийн саналын эрхтэй хувьцааны 98.41 хувийн ирцтэй хуралдсан.

МИК ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН БҮТЭЦ



“МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК” ХХК-ИЙН БҮТЭЦ

(“МИК Холдинг” ХК-ийн охин компани)



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- 1 дүгээр сарын 01.** Төлбөр тооцоо, санхүү бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд NES системийг бүрэн нэвтрүүлж, автоматжууллаа.
- 1 дүгээр сарын 12.** Олон улсын хөрөнгийн зах зээлээс 225 сая ам.долларын “Хулан” бондыг амжилттай арилжааллаа.
- 2 дугаар сарын 09.** 2021 онд олон улсын зах зээлд арилжаалсан 250 сая ам.долларын “Бөртэ” бондын үндсэн болон купоны төлбөрийг амжилттай төлж дууслаа.
- 2 дугаар сарын 16.** Дотоодын биржийн бус зах зээл дээр 8.4 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээ.
- 2 дугаар сарын 26.** “МИК Холдинг” ХК Тогтвортой хөгжлийн бодлого баталлаа.
- 3 дугаар сарын 01.** Барьцаа хөрөнгө чөлөөлөх зарим үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд илүү хялбар боллоо.
- 4 дүгээр сарын 04.** Дотоодын биржийн бус зах зээл дээр 4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээ.
- 4 дүгээр сарын 17.** Олон улсын Нийцлийн менежментийн тогтолцооны “ISO37301:2021” стандартын магадлах аудитыг хоёр дахь жилдээ амжилттай хийлгэж, сертификатаа гардан авлаа.
- 7 дугаар сарын 05.** “МИК Актив гучин тав ТЗК” ХХК-иар дамжуулан 3,702 өрхийн 346.7 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргав.
- 7 дугаар сарын 18.** Олон улсын зах зээл дээр гаргасан 225 сая ам.долларын "Хулан" бондын анхны купоны төлөлтийг амжилттай гүйцэтгэлээ.
- 10 дугаар сарын 15.** "МИК Актив гучин зургаа ТЗК" ХХК-иар дамжуулан 2,120 өрхийн 159.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргав.
- 10 дугаар сарын 31.** Зээлийн нэгдсэн хөрөнгийн багц дахь орон нутгийн 17 аймагт байрлалтай чанаргүй зээлийн газар дээрх хяналтыг хэрэгжүүлж, эрсдэлтэй барьцаа хөрөнгийн биет байдалтай танилцан, үйлчилгээ үзүүлэгч банкуудад зээлийн эрсдэл болон даатгалын хамрагдалтын талаар сургалтыг 4 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд зохион байгууллаа.
- 11 дүгээр сарын 15.** Олон улсын Эрсдэлийн менежментийн “ISO31000:2018” стандартыг удирдлагын тогтолцоонд нэвтрүүлсэнийг хөндлөнгийн баталгаажуулалтын компаниар хоёр дахь жилдээ магадлан аудит хийлгэн дахин баталгаажууллаа.
- 11 дүгээр сарын 19.** МИК-д худалдсан болон худалдахаар хүлээгдэж байгаа орон сууцны ипотекийн зээлийн мэдээллийг цахимаар иргэд өөрсдөө шалгах боломжтой боллоо.
- 12 дугаар сарын 02.** Монголын Тогтвортой Санхүүгийн форумын арга хэмжээний үеэр МИК нь тогтвортой санхүүжилт, байгаль орчин, нийгэм засаглалын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлуудаараа үнэлэгдэн “2024 оны Онцлох ТоС байгууллага”-аар шалгарлаа.
- Тэрбум мод хөдөлгөөн** Тэрбум мод хөдөлгөөнийг үргэлжлүүлж Банкны 100 жилийн ойн хүрээнд Эко цэцэрлэгт хүрээлэнд, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байршиж буй "МИК-ийн төгөл" зэрэг газруудад нийт 2,242 ширхэг мод тарилаа.

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“МИК ОССК” ХХК нь нь орон сууцны зээл олгогч банкнуудын хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор ипотекийн зээлийн хөрөнгийн багцыг бэлэн мөнгө болон санхүүгийн бусад хэрэгслээр худалдан авах, арилжих үйл ажиллагаа явуулж байна. Орон сууцны зээлийн хөрөнгийг худалдан авах хэлцлийг зээлийн хөрөнгийн эрсдэлийг шилжүүлэх нөхцөлөөр нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:


1. Буцаахгүй нөхцөлтэй хэлцэл: (Purchase Without Recourse)

Зээлийн хөрөнгөөс орж ирэх өгөөж болон учирч болох эрсдэлийг аль алиныг нь шилжүүлэн авах нөхцөлтэй хэлцэл. Монголбанкнаас хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үйл ажиллагааны хүрээнд олгогдсон зээлийн хөрөнгийг ИЗББ-оор арилжих үйл ажиллагааг энэ хэлцлийн хүрээнд гүйцэтгэж байна.

2. Буцаах нөхцөлтэй хэлцэл: (Purchase With Recourse)

Зээлийн хөрөнгөд эрсдэл учирсан тохиолдолд эсхүл “Худалдагч тал”-д буюу зээл олгосон банканд тухайн зээлийн хөрөнгийг буцаан худалдах эсхүл өөр зээлийн хөрөнгөөр солих нөхцөлтэй хэлцэл.


Худалдан авалтын төрөл



Буцаахгүй нөхцөлтэй хэлцэл

“МИК ОССК” ХХК нь 2024 онд нийт 506.8 тэрбум төгрөгийн багцыг буцаахгүй нөхцөлтэйгөөр худалдан авч, үнэт цаасжуулах ажлыг гүйцэтгэв.

2024 оны төлөвлөгөө ба гүйцэтгэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж “МИК ОССК” ХХК

Үнэт цаасжуулалт – ИЗББ


Банк, санхүүгийн байгууллагын тайлан тэнцэл дэх урт хугацаатай ипотекийн зээл, бусад санхүүгийн авлагыг багцалж, эдгээр хөрөнгө болон түүнээс орж ирэх мөнгөн урсгалаар баталгаажуулан үнэт цаас гаргах замаар шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг зах зээлээс татах ажиллагааг үнэт цаасжуулалт гэдэг.

“МИК ОССК” ХХК нь орон сууцны санхүүжилтийн тогтолцоонд урт хугацаат ипотекийн зээлийг үнэт цаасжуулах замаар зээл олгогч банкуудын хөрвөх чадварыг сайжруулах, улмаар орон сууцны зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу “МИК ОССК” ХХК нь ТЗК-ийг үүсгэн байгуулж, холбогдох тусгай зөвшөөрлийг СЗХ-ноос авснаар ИЗББ-ыг хөрөнгийн зах зээлд арилжих эрхтэй болдог.

ЗГОСИЗХ-ийн хүрээнд “МИК ОССК” ХХК нь 36 удаагийн хэлцлийг гүйцэтгэж 6.9 их наяд төгрөгийн ИЗББ-ыг гаргасан байна. Үүнээс 2024 онд ИЗББ 35-36 дугаар хэлцлээр дамжуулан нийт 506.3 тэрбум төгрөгийн ИЗББ-ыг орон сууцны ипотекийн зээлийн хөрөнгөөр арилжих хэлцлийг хийж гүйцэтгэлээ.

Нийт ИЗББ-ын мэдээлэл




Эх сурвалж “МИК ОССК” ХХК

Буцаах нөхцөлтэй хэлцэл

“МИК ОССК” ХХК нь банк болон санхүүгийн байгууллагаас зээлийн хөрөнгийн багцыг буцаах нөхцөлтэйгөөр худалдан авах үйл ажиллагааг 2008 оноос эхлэн гүйцэтгэж байна. Энэхүү үйл ажиллагаа нь банкны хөрвөх чадварыг сайжруулж, зээлийн шинэ эх үүсвэрийг бий болгосноор дахин зээл олгох боломжийг бүрдүүлдэг. Нөгөө талаас банкуудын эх үүсвэрийн зардлыг бууруулж, хугацааг уртасгаж улмаар зээлдэгчийн орон сууцны зээлийн нөхцөлийг сайжруулдаг.

Тус үйл ажиллагааны хүрээнд “МИК ОССК” ХХК нь өөрийн эх үүсвэр, Германы сэргээн босголт, зээлийн банкны эх үүсвэр, Ам.долларын бондын эх үүсвэр болон МИК бондын эх үүсвэрээр 13 банк, 14 банк бус санхүүгийн байгууллагаас 175 удаагийн хэлцлээр нийт 1,683.78 тэрбум төгрөгийн багцыг худалдан авсан байна. Үүнээс тайлант хугацаанд олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр 164.08 тэрбум төгрөгийн багцыг худалдан авсан байна.


Буцаах нөхцөлтэй багцын жигнэсэн дундаж хүү, багцын үлдэгдэл



Эх сурвалж “МИК ОССК” ХХК

Буцаах нөхцөлтэй багцын эх үүсвэрийн бүтэц

Буцаах нөхцөлтэй багц дахь зээлийн барьцаа хөрөнгийн бүтцийг харуулбал, 80.03 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай барьцаа хөрөнгө болон автомашин, 19.97 хувийг амьдран суух зориулалттай барьцаа хөрөнгө эзэлж байна.



Эх сурвалж “МИК ОССК” ХХК

"МИК ХОЛДИНГ" ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

№25/05

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.6 дахь заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 7.15 дахь заалт, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Санхүү, аудитын хорооны 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 2 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэ тогтоолын 2-т заасан санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
4. Энэ тогтоолын 2-т заасан тайлангуудыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэр гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ХАШЧУЛУУН



Ernst & Young Mongolia Audit LLC Tel: +976 11 314032 / +976 11 312005
15/F, Altan Joloo Tower ey.com
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МИК Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг МИК Холдинг ХК болон охин компаниуд (“Групп”)–ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Группын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)–ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Группын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэнд Аудитын онцгойлсон асуудлууд багтсан. Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт” байсан.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группын удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын олон улсын стандарт (“АОУС”) 810 буюу “Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил”–ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид ХХК



ДОРЖБАТЫН МАНДАХБАЯР
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 3 дугаар сарын 18

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн
Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан

	2024 MNT'000	2023 MNT'000
Хүү болон түүнтэй адилтгах орлого	385,014,458	372,691,947
Хүүний зардал	(333,987,188)	(289,467,241)
Хүүний цэвэр орлого	51,027,270	83,224,706
Шимтгэл, хураамжийн зардал	(19,290,395)	(17,949,733)
Нийт үйл ажиллагааны орлого	31,736,875	65,274,973
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт/(зардал)	(2,615,084)	624,992
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгийн цэвэр олз/(гарз)	(1,928,346)	1,245,099
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн цэвэр олз/(гарз)	1,070,924	(8,038,358)
Нийт үйл ажиллагааны ашиг	28,264,369	59,106,706
Үйл ажиллагааны зардал	(19,666,830)	(17,188,289)
Бусад орлого/(зардал), цэвэр	(38,611,293)	2,764,812
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	(30,013,754)	44,683,229
Орлогын албан татварын зардал	(7,040,581)	(16,569,573)
Нийт дэлгэрэнгүй орлого/(алдагдал)-ыг илэрхийлэх тайлант жилийн ашиг/(алдагдал)	(37,054,335)	28,113,656
Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал) (төгрөгөөр)		
Нэгж хувьцаанд ногдох суурь болон шингэрүүлсэн ашиг/(алдагдал)	(2,430.29)	1,843.89

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн

Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан

	2024 мян.төг	2023 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах, хадгаламж	212,851,957	343,498,698
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	288,307,003	131,545,865
Буцаах нөхцөлтэй орон сууцны зээлийн багцын авлага	228,500,361	203,662,983
Буцаах нөхцөлтэй зээлийн багцын авлага	40,695,387	23,905,581
Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлага	4,121,074,245	4,082,796,161
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө	128,172,138	137,673,182
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,950,282	152,847,243
Бусад хөрөнгө	51,461,130	59,365,821
Үндсэн хөрөнгө	33,153,766	34,800,079
Биет бус хөрөнгө	904,474	260,948
Урьдчилж төлсөн орлогын албан татвар	230,790	190,620
Хойшлогдсон татварын хөрөнгө	100,135	9,619,187
НИЙТ ХӨРӨНГӨ	5,107,401,668	5,180,166,368
ӨР ТӨЛБӨР		
Бусад өр төлбөр	23,551,682	18,241,664
Зээлээр авсан эх үүсвэр	24,382,523	9,577,148
Өрийн үнэт цаас	726,128,478	760,736,859
Баталгаажсан бонд	4,308,848,566	4,317,570,902
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	39,915	-
Орлогын албан татварын өглөг	1,849,203	1,976,169
Хойшлогдсон татварын өр	21,391,844	33,799,834
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,106,192,211	5,141,902,576
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	20,709,320	20,709,320
Нэмэгдэж төлөгдсөн капитал	52,225,115	52,225,115
Халаасны хувьцаа	(62,143,136)	(62,143,136)
Нөөц	(9,581,842)	27,472,493
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	1,209,457	38,263,792
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,107,401,668	5,180,166,368

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь түүний охин компаниудын Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын бүрэн эрх, “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ нь ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь зургаан ердийн гишүүн, гурван хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд банк санхүү, хөрөнгийн зах зээлийн талаарх өргөн мэдлэг туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

№	ТУЗ	Нэр	Ажил, албан тушаал
1.	ТУЗ-ийн дарга (Хараат бус гишүүн)	Чулуундоржийн Хашчулуун	Монгол Улсын Их Сургуулийн Дэд профессор
2.	Ердийн гишүүн	Атарбаатарын Энхжин	Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал
3.	Ердийн гишүүн	Бат-Өлзийн Сайнзаяа	Монгол Улсын Хөгжлийн банкны Төслийн санхүүжилтийн газрын захирал
4.	Ердийн гишүүн	Мягмарын Мөнхбаатар	"Азиа Дайверсифайд Рийл Эстэйт Фанд Нэг" ХХК-ийн зөвлөх
5.	Ердийн гишүүн	Товуудоржийн Даваажав	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
6.	Ердийн гишүүн	Нямдоржийн Сэргэлэн	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
7.	Ердийн гишүүн	Батцэнгэлийн Үүрцайхбаатар	Капитрон банкны Гүйцэтгэх захирал
8.	Хараат бус гишүүн	Энхбаярын Шижир	Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн удирдагч
9.	Хараат бус гишүүн	Амаржаргалын Анар	"Синержи Фанд" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

2024 ОНЫ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Хурлын нэр	Хурлын тоо	Хурлын дундаж ирц
1.	“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурал	6	72.2 %
2.	“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	66.6 %
3.	“МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн хурал	11	76.7 %
4.	"МИК Рийл Эстэйт" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	66.6 %
5.	Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал	103	79 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд байнгын үйл ажиллагаатай (4) хороо үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

- Санхүү, аудитын хороо
- Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Тогтортой хөгжлийн хороо

САНХҮҮ, АУДИТЫН ХОРОО

Хорооны дарга: Э.Шижир

Гишүүд: Т.Даваажав, Ч.Хашчулуун, А.Анар

Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосны дагуу тус хорооны дарга болон дийлэнх олонх нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрддэг.

Чиг үүрэг:

ТУЗ-д удирдан чиглүүлэх болон хянан шалгах үүргээ үр ашигтай, бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслах, компанийн санхүүгийн төсөв, тайланд хяналт тавих, хөндлөнгийн аудитортой харилцаж ажиллах, дотоод аудитын үйл ажиллагааг бодлого, журмаар хангах асуудлыг хариуцна.

Хурлын тухай:

Тус хороо нь тайлант хугацаанд 4 удаагийн хурлаар нийт 4 дүгнэлт гаргасан.
Хурлын дундаж ирц 75 хувь.

НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ХОРОО

Хорооны дарга: Ч.Хашчулуун

Гишүүд: М.Мөнхбаатар, Э.Шижир, А.Анар

Чиг үүрэг:

Компанийн засаглалын тогтолцоо, түүнд хамаарах санхүү, дотоод хяналттай холбоотой баримт бичгээс бусад бодлого, дүрэм журам, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлт, хэрэгжилтэд хяналт тавина. Мөн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага (ГУ) болон ТУЗ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг албан тушаалтныг сонгон шалгаруулах, тавигдах шаардлагыг тодорхойлох, нэр дэвшүүлэх, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ТУЗ болон ГУ-ын үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулах, асуудлыг хариуцна.

Хурлын тухай:

Тус хороо нь тайлант хугацаанд 7 удаагийн хурлаар нийт 16 дүгнэлт гаргасан.
Хурлын дундаж ирц 75 хувь.

ЭРСДЭЛИЙН УДИРДАГЫН ХОРОО

Хорооны дарга: А.Энхжин

Гишүүд: Б.Сайнзаяа, Б.Үүрцайхбаатар, Н.Сэргэлэн

Чиг үүрэг:

Эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд хяналт тавих, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг хянах, дүгнэх асуудлыг хариуцна.

Хурлын тухай:

Тус хороо нь тайлант хугацаанд 3 удаагийн хурлаар нийт 6 дүгнэлт гаргасан.
Хурлын дундаж ирц 83.3 хувь.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРОО

Хорооны дарга: Н.Сэргэлэн

Гишүүд: А.Энхжин, Э.Шижир

Чиг үүрэг:

Компанийн тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийн гүйцэтгэлийг тогтмол сайжруулах, хэмжүүр үзүүлэлт, тайлагналд хяналт тавих асуудлыг хариуцна.

Хурлын тухай:

Тус хороо нь тайлант хугацаанд 2 удаагийн хурлаар нийт 2 дүгнэлт гаргасан.

Хурлын ирц 100 хувь.

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин нь суурь болон нэмэгдэл цалингаас бүрддэг. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар болгон олгогдох тогтмол цалин. Мөн нэмэгдэл цалинг "ТУЗ-ийн гишүүдэд нэмэгдэл цалинг тооцоох аргачлал"-ын дагуу хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцож, улиралд нэг удаа олгодог. Цалинг зохих татвар, суутгалыг суутган олгодог.

Цалингийн зардал	Давтамж	Хүний тоо	2024/05/01-2024/12/31		2025/01/01-2025/04/30	
			суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	12	9	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	12	9	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр компанийн стратеги төлөвлөгөө болон өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн төлөв байдал зэрэг асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт зөвлөх Д.Байлхүү, Д.Болдбаатар болон ТУЗ-ийн дарга Ч.Хашчулуун, хараат бус гишүүн Э.Шижир, ТУЗ-ийн гишүүн А.Энхжин, Т.Даваажав нар оролцож, санал бодлоо солилцлоо.

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ,
ШАГНАЛ УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ХУРЛЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар №3

Улаанбаатар хот

Дүгнэлт

1. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэлх хугацаанд олгох цалингийн зардлын төсвийн саналыг энэ дүгнэлтийн Хавсралтад зааснаар гаргав.
2. Энэ дүгнэлтийн Хавсралтад заасан цалингийн зардлын төсвийн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхийг тус хорооны дарга (Ч.Хашчулуун)-д даалгав.

ХОРООНЫ ДАРГА

Ч.ХАШЧУЛУУН

*“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх
Нэр, дэвшүүлэх шагналыг урамшууллын хорооны
2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн
хурлын 3 дугаартай дүгнэлтийн Хавсралт*

**"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Зардлын төрөл	Сарын цалин		Давтамж	Хүний тоо	Нийт			Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			суурь	нэмэгдэл	нийт	2025/05/01-2025/12/31		2026/01/01-2026/04/30	
								суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	86,100	61,500	12	9	9,298,800	6,642,000	15,940,800	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	786,100	561,500	12	9	84,898,800	60,642,000	145,540,800	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар №25/01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 25/05 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Ч.ХАШЧУЛУУН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

Дугаар №25/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 4.12 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2025 оны 3 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны 5 дугаар 01-ний өдрөөс 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэлх цалингийн зардлын төсвийг энэ тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

Ч.ХАШЧУЛУУН

*“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын
25/02 дугаартай тогтоолын Хавсралт*

"МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Зардлын төрөл	Сарын цалин		Давтамж	Хүний тоо	Нийт			Үүнээс:			
	суурь	нэмэгдэл			суурь	нэмэгдэл	нийт	2025/05/01-2025/12/31		2026/01/01-2026/04/30	
								суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	700,000	500,000	12	9	75,600,000	54,000,000	129,600,000	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	86,100	61,500	12	9	9,298,800	6,642,000	15,940,800	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	786,100	561,500	12	9	84,898,800	60,642,000	145,540,800	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС - 1

Хурлын мэдээлэл:

- | | |
|-----------------------|---------------------|
| 1. Хурлын төрөл: | Ээлжит |
| 2. Хурлын хэлбэр: | Цахим /live.mik.mn/ |
| 3. Хурлын огноо, цаг: | 2025.04.30, 11:00 |

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

- | | |
|------------------------------------|--------------|
| 1. Хувьцаа эзэмшигчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: | Энгийн |
| 4. Эзэмшиж буй хувьцааны тоо: | ширхэг |
| 5. Утасны дугаар: | |
| 6. И-мэйл хаяг: | |
| 7. Үнэт цаасны компанийн нэр: | |

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл:

- | | |
|-----------------------|-------|
| 1. Төлөөлөгчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Утасны дугаар: | |

Санал хураалтын арга:

Ердийн

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	№25/01			

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний

итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг: _____ / _____ /
гарын үсгийн тайлал

Санал авах хуудсыг бөглөн, хүргүүлсэн огноо, цаг: _____

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Санал авах хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Дарга:

Гишүүн:

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....
.....
.....
.....

Санал авах хуудсыг бөглөх, хүргүүлэх санамж:

1. Хувьцаа эзэмшигч та саналаа тэмдэглэхдээ санал өгөх гурван хувилбарын зөвхөн аль нэгээр саналаа илэрхийлэх боломжтой ба дурын тэмдэглэгээг хийнэ үү. Жишээг доорх хүснэгтээр харуулав.

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	[•]	[•]	+		

2. Засварласан, балласан, залруулгатай, эсвэл давхар тэмдэглэгээ хийсэн бол санал авах хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.
3. Хэрэв санал авах хуудсыг буруу бөглөсөн бол Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө санал авах хуудсыг дахин шинээр бөглөж хүргүүлэх боломжтой.
4. Хувьцаа эзэмшигч Та саналаа хурлаас өмнө урьдчилж өгөх боломжтой бөгөөд үнэт цаасны компанид, эсвэл Тооллогын комисст 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаас өмнө санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хувьцаа эзэмшигч Та санал авах хуудсыг хүлээлгэн өгөхдөө баталгаажуулах бичиг баримтыг заавал хавсаргасан байх шаардлагатай.
 - Хувьцаа эзэмшигч хувь хүний иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспортын хуулбар;
 - Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан /Гүйцэтгэх захирал/-ы иргэний үнэмлэхийн хуулбар; эсвэл
 - Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл болон төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС - 2**

Хурлын мэдээлэл:

- | | |
|-----------------------|---------------------|
| 1. Хурлын төрөл: | Ээлжит |
| 2. Хурлын хэлбэр: | Цахим /live.mik.mn/ |
| 3. Хурлын огноо, цаг: | 2025.04.30, 11:00 |

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

- | | |
|------------------------------------|--------------|
| 1. Хувьцаа эзэмшигчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: | Энгийн |
| 4. Эзэмшиж буй хувьцааны тоо: | ширхэг |
| 5. Утасны дугаар: | |
| 6. И-мэйл хаяг: | |
| 7. Үнэт цаасны компанийн нэр: | |

Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл:

- | | |
|-----------------------|-------|
| 1. Төлөөлөгчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Утасны дугаар: | |

Санал хураалтын арга: Ердийн

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай	№25/02			

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний

итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг: _____ / _____ /
гарын үсгийн тайлал

Санал авах хуудсыг бөглөн, хүргүүлсэн огноо, цаг: _____

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Санал авах хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Дарга:

Гишүүн:

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....

.....

.....

.....

.....

.....

Санал авах хуудсыг бөглөх, хүргүүлэх санамж:

1. Хувьцаа эзэмшигч та саналаа тэмдэглэхдээ санал өгөх гурван хувилбарын зөвхөн аль нэгээр саналаа илэрхийлэх боломжтой ба дурын тэмдэглэгээг хийнэ үү. Жишээг доорх хүснэгтээр харуулав.

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	[•]	[•]	+		

2. Засварласан, балласан, залруулгатай, эсвэл давхар тэмдэглэгээ хийсэн бол санал авах хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.
3. Хэрэв санал авах хуудсыг буруу бөглөсөн бол Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө санал авах хуудсыг дахин шинээр бөглөж хүргүүлэх боломжтой.
4. Хувьцаа эзэмшигч Та саналаа хурлаас өмнө урьдчилж өгөх боломжтой бөгөөд үнэт цаасны компанид, эсвэл Тооллогын комисст 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаас өмнө санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хувьцаа эзэмшигч Та санал авах хуудсыг хүлээлгэн өгөхдөө баталгаажуулах бичиг баримтыг заавал хавсаргасан байх шаардлагатай.
 - Хувьцаа эзэмшигч хувь хүний иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспортын хуулбар;
 - Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан /Гүйцэтгэх захирал/-ы иргэний үнэмлэхийн хуулбар; эсвэл
 - Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл болон төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БҮРТГҮҮЛЭХ БОЛОН ОРОЛЦОЖ, САНАЛ ӨГӨХ ЗААВАР

“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт live.mik.mn сайтаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн цахим хурлын программд бүртгүүлэх:

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч live.mik.mn сайт дахь цахим хурлын программд бүртгүүлэх хүсэлтийг бөглөн илгээх бөгөөд ирүүлсэн хүсэлтийг 24 цагийн дотор хянаж, бүрэн баталгаажуулснаар хувьцаа эзэмшигчийн цахим хурлын программд нэвтрэх эрх үүснэ.

Хэрэв та санал авах хуудсаар дамжуулан урьдчилан санал өгөх бол цахим хурлын программд бүртгүүлэх хүсэлтийг заавал бөглөх шаардлагагүй бөгөөд таны ирүүлсэн санал авах хуудас болон баталгаажуулах бичиг баримтыг үндэслэн цахим хурлын программд бүртгэлийг үүсгэнэ.

Урьдчилан санал өгөх:

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч санал авах хуудас эсвэл, эсвэл live.mik.mn сайт руу нэвтрэх “Урьдчилж санал өгөх” цэсээр дамжуулан 2025 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 17:00 хүртэл саналаа урьдчилан өгч болно.

Хувьцаа эзэмшигчид “Санал авах хуудас” дахь санамжтай сайтар танилцана уу.

Цахим хуралд оролцож, санал өгөх:

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь live.mik.mn сайт дахь “Нэвтрэх” хэсэгт хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар болон бүртгүүлсэн гар утасны дугаар руу илгээгдсэн нэг удаагийн нэвтрэх кодыг оруулсанаар цахим хурлын программд нэвтрэх хуралд оролцож, санал өгнө.

Хуралд оролцохын тулд цахим хурлын программд урьдчилан бүртгэгдсэн байх шаардлагатай болохыг анхаарна уу.

Баталгаажуулах бичиг баримт:

- Хувьцаа эзэмшигч хувь хүн: иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспортын хуулбар;
- Хувьцаа эзэмшигч хуулийн этгээд: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар;
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Итгэмжлэл, төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.

Нэмэлт мэдээлэл:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй үнэт цаасны компаниудад цахим болон цаасан хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын танилцуулгыг хүлээлгэн өгсөн.
- Хурал нээх ирцийг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00-11:15 цагийн хооронд хурлын программ руу амжилттай нэвтрэх орсон болон урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн нийт хувьцааны тоогоор тооцно.
- Хурлаар шийдвэрлэх асуудлуудад санал авах нийт хугацаа 10 минут үргэлжлэх ба энэ хугацаанд багтаан санал ирүүлээгүй бол тухайн хувьцаа эзэмшигчийг санал өгөөгүйд тооцно.
- Хурлаар шийдвэрлэх асуудал тус бүрээр ирц болон санал хураалтын дүнг хурлын өдрийн 11:00 цагаас эхлэн санал хураалт дууссан цагийн хооронд хурлын программ руу амжилттай нэвтрэх, санал өгсөн болон урьдчилж санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн нийт хувьцааны тоогоор тооцно.
- Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд бүртгүүлэх, оролцож, санал өгөхтэй холбоотой тодруулах зүйл байвал Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул, 95908267), эсвэл Хурлын тооллогын комисс (Н.Болор-Эрдэнэ, 99095222)-той холбогдоно уу.
- Компанийн байранд биечлэн хүрэлцэн ирэх бол та Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд урьдчилан мэдэгдэнэ үү.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА БОЛОН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС



Утас: 11-328267
Цахим хуудас: www.mik.mn

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тойруу, Д.Сүхбаатарын
талбай гудамж, 11 тоот



“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын
25/07 дугаартай тогтоолын Хавсралт №5

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС - 2**

Хурлын мэдээлэл:

- | | |
|-----------------------|---------------------|
| 1. Хурлын төрөл: | Ээлжит |
| 2. Хурлын хэлбэр: | Цахим /live.mik.mn/ |
| 3. Хурлын огноо, цаг: | 2025.04.30, 11:00 |

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

- | | |
|------------------------------------|--------------|
| 1. Хувьцаа эзэмшигчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: | Энгийн |
| 4. Эзэмшиж буй хувьцааны тоо: | ширхэг |
| 5. Утасны дугаар: | |
| 6. И-мэйл хаяг: | |
| 7. Үнэт цаасны компанийн нэр: | |

Хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл:

- | | |
|-----------------------|-------|
| 1. Төлөөлөгчийн нэр: | |
| 2. Регистрийн дугаар: | |
| 3. Утасны дугаар: | |

Санал хураалтын арга:

Ердийн

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг батлах тухай	№25/02			

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний

итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг: _____ / _____ /
гарын үсгийн тайлал

Санал авах хуудсыг бөглөн, хүргүүлсэн огноо, цаг: _____

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Санал авах хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Дарга:

Гишүүн:

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....
.....

Санал авах хуудсыг бөглөх, хүргүүлэх санамж:

1. Хувьцаа эзэмшигч та саналаа тэмдэглэхдээ санал өгөх гурван хувилбарын зөвхөн аль нэгээр саналаа илэрхийлэх боломжтой ба дурын тэмдэглэгээг хийнэ үү. Жишээг доорх хүснэгтээр харуулав.

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	[•]	[•]	+		

2. Засварласан, балласан, залруулгатай, эсвэл давхар тэмдэглэгээ хийсэн бол санал авах хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.
3. Хэрэв санал авах хуудсыг буруу бөглөсөн бол Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө санал авах хуудсыг дахин шинээр бөглөж хүргүүлэх боломжтой.
4. Хувьцаа эзэмшигч Та саналаа хурлаас өмнө урьдчилж өгөх боломжтой бөгөөд үнэт цаасны компанид, эсвэл Тооллогын комисст 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаас өмнө санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хувьцаа эзэмшигч Та санал авах хуудсыг хүлээлгэн өгөхдөө баталгаажуулах бичиг баримтыг заавал хавсаргасан байх шаардлагатай.
- Хувьцаа эзэмшигч хувь хүний иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспортын хуулбар;
 - Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан /Гүйцэтгэх захирал/-ы иргэний үнэмлэхийн хуулбар; эсвэл
 - Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл болон төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.



“МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын
25/06 дугаартай тогтоолын Хавсралт №4

**“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС - 1**

Хурлын мэдээлэл:

- Хурлын төрөл: Ээлжит
- Хурлын хэлбэр: Цахим /live.mik.mn/
- Хурлын огноо, цаг: 2025.04.30, 11:00

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл:

- Хувьцаа эзэмшигчийн нэр:
- Регистрийн дугаар:
- Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн
- Эзэмшиж буй хувьцааны тоо:
- Утасны дугаар: ширхэг
- И-мэйл хаяг:
- Үнэт цаасны компанийн нэр:

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл:

- Төлөөлөгчийн нэр:
- Регистрийн дугаар:
- Утасны дугаар:

Санал хураалтын арга:

Ердийн

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай	№25/01			

Хувьцаа эзэмшигч, эсвэл түүний

итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг: _____ / _____ /
гарын үсгийн тайлал

Санал авах хуудсыг бөглөн, хүргүүлсэн огноо, цаг: _____

Тооллогын комиссын бөглөх хэсэг:

Санал авах хуудсыг хүчинтэй/хүчингүйд тооцон тоолсон:

Дарга:

Гишүүн:

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....
.....

Санал авах хуудсыг бөглөх, хүргүүлэх санамж:

1. Хувьцаа эзэмшигч та саналаа тэмдэглэхдээ санал өгөх гурван хувилбарын зөвхөн аль нэгээр саналаа илэрхийлэх боломжтой ба дурын тэмдэглэгээг хийнэ үү. Жишээг доорх хүснэгтээр харуулав.

№	Хэлэлцэх асуудал	Тогтоолын төслийн дугаар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	[•]	[•]	+		

2. Засварласан, балласан, залруулгатай, эсвэл давхар тэмдэглэгээ хийсэн бол санал авах хуудас хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.
3. Хэрэв санал авах хуудсыг буруу бөглөсөн бол Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө санал авах хуудсыг дахин шинээр бөглөж хүргүүлэх боломжтой.
4. Хувьцаа эзэмшигч Та саналаа хурлаас өмнө урьдчилж өгөх боломжтой бөгөөд үнэт цаасны компанид, эсвэл Тооллогын комисст 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаас өмнө санал авах хуудсыг хүлээлгэн өгнө үү.
5. Хувьцаа эзэмшигч Та санал авах хуудсыг хүлээлгэн өгөхдөө баталгаажуулах бичиг баримтыг заавал хавсаргасан байх шаардлагатай.
- Хувьцаа эзэмшигч хувь хүний иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспортын хуулбар;
 - Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан /Гүйцэтгэх захирал/-ы иргэний үнэмлэхийн хуулбар; эсвэл
 - Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл болон төлөөлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар.